



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 03 сарын 13 өдөр

Дугаар #127

Улаанбаатар хот

Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээгээр зорчуулах, улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 213 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 4/14 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/724 дүгээр захирамж, 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Тээврийн газрын дүрэм”-ийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, авто замын зорчих хэсгийн 1 дүгээр эгнээгээр зорчуулах, улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх журам”-ыг нэгдүгээр, тээвэрлэлтийн мэдээг ирүүлэх хүснэгтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. Өөрчилсөн

2. Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэж бүртгэлийн сан үүсгэх, улсын дугаарын хязгаарлалт тогтоосон авто замын зорчих хэсгийн 1 дүгээр эгнээгээр зорчуулах мэдээллийг Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв болон Замын Цагдаагийн албаны Нийслэлийн Замын хөдөлгөөний хяналтын газарт хүргүүлэх, тээвэрлэлтийн мэдээг нэгтгэж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, автобусыг тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт оруулах ажлыг хуваарын дагуу зохион байгуулж, шуурхай хийж гүйцэтгэхийг Техникийн үзлэг, оношилгооны төв /Ц.Нанжид/-д, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус үүрэг болгосугай. Өөрчилсөн

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д даалгасугай.

ДАРГА

Д.ОТГОНБААТАР



D:\alban khereg\Явсан бичиг 2017\TUSHAAL.docx

1115108253 :: 2117428

Газрын даргын - ны 2017 оны А/85 д. Тушаалар 1150500145

